



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 05 өдөр

Дугаар 8/449

Мөрөн сум

Үйл ажиллагааны жагсаалт,
төсөвт өртөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.3, 41.2.6, 65 дугаар зүйлийн 65.1.1, 65.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдана авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, Засгийн газрын 2023 оны 409 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Ахмадын өргөөний барилга /Хөвсгөл, Улаан-Уул, Мөрөн, Эрдэнэбулган сум/” барих ажлын жагсаалт, төсөвт өртгийг 01 дүгээр хавсралтаар “Нийтийн халуун усны барилга /Хөвсгөл, Арбулаг, Бүрэнтогтох, Шинэ-Идэр сум/ ажлын жагсаалт, төсөвт өртгийг 02 дугаар хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Должинсоргодог)-д үүрэг болгосугай.

3. Ахмадын өргөөний барилга /Хөвсгөл, Улаан-Уул, Мөрөн, Эрдэнэбулган сум/, Нийтийн халуун усны барилга /Хөвсгөл, Арбулаг, Бүрэнтогтох, Шинэ-Идэр сум/ барих ажлын гүйцэтгэгч сонгох худалдан авах ажлыг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны 09 дугаар
сарын 05-ны өдрийн А/44 дугаар
захирамжийн хавсралт 1

АХМАДЫН ӨРГӨӨНИЙ БАРИЛГА /ХӨВСГӨЛ, УЛААН-УУЛ, МӨРӨН, ЭРДЭНЭБУЛГАН
СУМ/ БАРИХ АЖЛЫН ХҮРЭЭНД УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2024 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ЖАГСААЛТ

№	Үйл ажиллагаа	Тоо ширхэг	Шаардагдах хөрөнгө /сая. Төг/
1	Ахмадын өргөөний барилга /Улаан-Уул сум/	1	480,000,000
2	Ахмадын өргөөний барилга /Мөрөн сум/	1	480,000,000
3	Ахмадын өргөөний барилга /Эрдэнэбулган сум/	1	480,000,000
Нийт			1,440,000,000

оОо

Аймгийн Засаг даргын 2024 оны 09 дугаар
сарын 05-ны өдрийн А/449 дугаар
захирамжийн хавсралт 2

НИЙТИЙН ХАЛУУН УСНЫ БАРИЛГА /ХӨВСГӨЛ, АРБУЛАГ, БҮРЭНТОГТОХ, ШИНЭ-ИДЭР
СУМ/ БАРИХ АЖЛЫН ХҮРЭЭНД УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2024 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ЖАГСААЛТ

№	Үйл ажиллагаа	Тоо ширхэг	Шаардагдах хөрөнгө /сая. Төг/
1	Нийтийн халуун усны барилга /Арбулаг сум/	1	576,700,000
2	Нийтийн халуун усны барилга /Бүрэнтогтох сум/	1	576,700,000
3	Нийтийн халуун усны барилга /Шинэ-Идэр сум/	1	576,700,000
Нийт			1,730,100,000

_____оОо_____